



I-IV/2022


Тархаасан: 2022 оны 5 дугаар сарын 12



Бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 6308 (80.4%) - аар өссөн байна

Бүртгэгдсэн гэмт хэрэг 2022 оны эхний 4 сард 14150 болж, өмнөх оны мөн үеэс 6308 (80.4%)-аар өсжээ. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс өсөхөд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 4894 (2.2 дахин), хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 1143 (49.3%), хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 179 (84.4%), хүний бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 90 (48.6%)-ээр өссөн нь голлон нөлөөлжээ.

ЗУРАГ 1. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, сараар



Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 739 хэргийн 54 (7.3%) нь Монгол Улсын Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйл (Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг)-ээр зүйлчлэгдсэн байна.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 2022 оны эхний 4 сард 54 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 13 (31.7%)-аар өсжээ. Харин 2022 оны 4 дүгээр сард 14 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх сарын түвшинд байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас 2022 оны эхний 4 сард 3910 зөрчил бүртгэгдсэний 2915 (74.6%) зөрчлийг шалган шийдвэрлэжээ. Бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн нийт зөрчил өмнөх оны мөн үеэс 490 (14.3%)-ээр, шийдвэрлэсэн гэр бүлийн хүчирхийллийн нийт зөрчил 558 (23.7%)-аар тус тус өсжээ.

16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг 2022 оны эхний 4 сард 65 болж, өмнөх оны мөн үеэс 28 (75.7%)-аар өссөн байна. Харин 2022 оны 4 дүгээр сард 16 болж, өмнөх сараас 1 (5.9%)-ээр буурчээ.


Эмэгтэй хүн оролцсон хэрэг 2022 оны эхний 4 сард 2106 болж, 1151 (2.2 дахин их)-ээр, согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 2037 болж, 682 (50.3%)-оор, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 739 болж, өмнөх оны мөн үеэс 255 (52.7%)-аар, бүлэглэн үйлдсэн хэрэг 608 болж, 199 (48.7%)-өөр хүүхэд оролцсон хэрэг 480 болж, 339 (3.4 дахин)-өөр, мансуурсан үедээ үйлдсэн хэрэг 72 болж, 10 (16.1%)-аар тус тус өсжээ.

ЗУРАГ 2. УЧИРСАН ХОХИРОЛ БОЛОН НӨХӨН ТӨЛҮҮЛСЭН ХОХИРОЛ, сараар, тэрбум төгрөгөөр



Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2022 оны эхний 4 сард 135.3 тэрбум төгрөг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 75.3 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс учирсан хохирол 80.5 (2.5 дахин) тэрбум төгрөгөөр, нөхөн төлүүлсэн хохирол 58.6 (4.5 дахин) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

ЗУРАГ 3. ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДСОН ЯЛЛАГДАГЧ, насны бүлгээр, жил бүрийн эхний 4 сарын байдлаар



Гэмт хэрэгт холбогдсон нийт яллагдагчдын тоо 2022 оны эхний 4 сард 8002 болж, өмнөх оны мөн үеэс 3309 (70.5%)-өөр өсжээ. Нийт гэмт хэрэгт холбогдсон яллагдагчийн 540 (6.7%) нь 18 хүртэлх насны хүүхэд, 1833 (22.9%) нь эмэгтэйчүүд байна.

ХҮСНЭГТ 1. ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС ХОХИРСОН, ГЭМТСЭН, НАС БАРСАН ХҮН, насны бүлгээр, хүйсээр, жил бүрийн эхний 4 сарын байдлаар


Үзүүлэлт	Хохирсон хүн		Гэмтсэн хүн		Нас барсан хүн		Гэмт хэргийн улмаас хохирсон хүн 2022 оны эхний 4 сард 13.8 мянга болж, 727 (5.3%) нь 18 хүртэлх насны хүүхэд, 6245 (45.2%) нь эмэгтэйчүүд байна. Гэмт хэргийн улмаас 2022 оны эхний 4 сард 3733 хүн гэмтэж, 321 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеэс гэмтсэн хүн 1273 (51.7%)-өөр, нас барсан хүн 76 (31.0%)-гаар өсжээ.
	2021	2022	2021	2022	2021	2022	
	I-IV	I-IV	I-IV	I-IV	I-IV	I-IV	
7 хүртэлх	47	46	19	24	18	11	
8-17	275	681	88	211	9	14	
18-29	1 939	3 640	678	1 098	34	46	
30-39	2 470	4 450	844	1 244	53	76	
40-49	1 607	2 853	483	691	59	69	
50-59	786	1 509	252	324	48	68	
60-69	261	525	69	112	17	29	
70, түүнээс дээш	76	113	27	29	7	8	
Улсын дүн	7 461	13 817	2 460	3 733	245	321	
Эмэгтэй	3 378	6 245	954	1 418	62	78	

Улсын хэмжээнд 2022 оны эхний 4 сард 26.1 мянган хүн эрүүлжүүлэгдэж, 5.3 мянган хүн баривчлагдсан нь өмнөх оны мөн үеэс эрүүлжүүлэгдсэн хүн 2534 (10.7%)-өөр, баривчлагдсан хүн 795 (17.5%)-аар тус тус өссөн байна.

Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтэст 2022 оны эхний 4 сард 154 авлигын хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 15 (10.8%)-аар өсжээ. Авлигын гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс өсөхөд эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэрэг 22 (20.8%)-оор өссөн нь голлон нөлөөлжээ.

Бүртгэгдсэн 154 авлигын хавтаст хэргийг Монгол Улсын Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлгийн зүйлээр ангилахад 128 (79.5%) нь эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, 19 (11.8%) нь хахууль авах гэмт хэрэг, 7 (4.4%) нь хахууль өгөх гэмт хэрэг, 4 (2.5%) нь үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэг, 2 (1.2%) нь төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах гэмт хэрэг, 1 (0.6%) нь хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах гэмт хэрэг байна.

ЗУРАГ 4. АВЛИГЫН ГЭМТ ХЭРЭГ, хэргийн төрлөөр, жил бүрийн эхний 4 сарын байдлаар



Ойлголт, тодорхойлолт

Гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.



16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг: Тухайн хугацаанд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоог 16, түүнээс дээш насны хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10000-аар үржүүлж тооцно.

Хохирогч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

Гэмт хэргийн хохирол: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Авлигын гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт зааснаар авлигын гэмт хэрэгт эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах, хахууль авах, хахууль өгөх, гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах, улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, үрэгдүүлэх, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах, төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах, үндэслэлгүйгээр хөрөнгөжих, дураараа аашлах, хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах гэмт үйлдлүүдийг хамруулна.

Яллагдагч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.

Эх үүсвэр:

Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл

Ангилал, код:

Гэмт хэргийн статистикийн олон улсын ангилал

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 6 дугаар сарын 12

Нийгмийн статистикийн газрын
дарга Э.Эрдэнэсан
Утас: (976-51)-266414

Нийгмийн статистикийн газрын
статистикч Ц.Дулмаа
Утас: (976-51)-263966

